



ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Шинэ коронавирусийн (nCoV) хариу арга хэмжээний эрсдэлийн үеийн харилцаа холбоо

ЗӨСҮТ, ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН
ТОГТОЛЦООНЫ БАГ





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДАЛААЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Үйл явдлын мэдээ:


	Холбогдох сайт	
Албан сайт	www.who.int	<ul style="list-style-type: none">- Novel Coronavirus – China- Novel Coronavirus – Thailand (ex-China)- Novel Coronavirus – Japan (ex-China)- Novel Coronavirus – Japan (ex-China)- Novel Coronavirus – Republic of Korea (ex-China)
Албан бус сайт	outbreaknewstoday.com	<ul style="list-style-type: none">- Thailand reports 1st Thai patient with coronavirus, country total now 4- Novel coronavirus reported in traveler in Washington State, Health screening to begin in Atlanta, Chicago- Novel coronavirus case confirmed in Taiwan
	statnews.com	<ul style="list-style-type: none">- CDC details first U.S. case of novel virus spreading in China- WHO calls for emergency meeting on new virus in China, as cases spread to health care workers- WHO raises possibility of ‘sustained’ human-to-human transmission of new virus in China
	www.dwnews.com	<ul style="list-style-type: none">- 北京毫不忌讳武汉封城之说 有场重要会议22日晚间召开- 武汉肺炎疫情】14名医护人员感染内情披露
	wjw.wuhan.gov.cn	<ul style="list-style-type: none">- 武汉市卫生健康委员会关于新型冠状病毒感染的肺炎情况通报
	www.reuters.com	<ul style="list-style-type: none">- Pandemic fears grow as China virus toll rises to nine





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДАЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ШАДАР САЙДЫН 2017 ОНЫ 08 ТУШААЛ



Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5.10.5

Эрсдэлийн мэдээлэл харилцааны багийн үүрэг

Зорилтот бүлгүүдийн, тэдний мэдээлэл, мэдлэгийн түвшинг тогтоож мэдээллийн стратеги, төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэх,

Мэдээллийг цаг тухайд нь, идэвхжилийн түвшин өөрчлөгдөх бүрт шинэчлэн боловсруулж, хүн амд оновчтой хувилбараар хүргэх,

Томилогдсон албан тушаалтан, мэргэжилтнийг мэдээллээр хангаж, олон нийтэд хандаж мэдээлэл хийлгэх ажлыг зохион байгуулах,

Хэвлэл мэдээллээр цацагдаж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, мониторинг хийж, цаашдын стратеги боловсруулах,

Үүссэн нөхцөл байдалтай холбоотой олон нийтийн санаа бодлыг сонсох, хариулт өгөх, судалгаа хийх, дүгнэлт гаргах, шуурхай утасны дугаарыг олон нийтэд зарлах,

Хүн ам, түншүүдийг хоорондоо зөрүүгүй мэдээллээс нэг эх үүсвэрээс, боломжит сувгаар түгээх, хэвлэлийн бага хурал, цахим хурал зохион байгуулах,

Иргэдийн дундах аман яриа, төсөөллийг тогтмол тандах,

Бусад салбар байгууллагуудтай хамтран нэгдсэн мэдээлэл боловсруулж түгээх

Дотоод гадаад түнш байгууллагуудад үйл явдлын мэдээлэл, тоймыг тогтмол бэлтгэн хүргүүлэх,





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

Эрсдэлийн үеийн харилцаа холбоо

Эрсдэлийн түвшин “бага”

- Багийн гишүүд болон түншлэгчдийг хэвлэл мэдээллийн сувгаар олон нийттэй харилцах, олон нийтийг дайчлах, иргэдтэй нүүр тулж ажиллах зэрэг эрсдэлийн мэдээлэл харилцааны арга барилд сургах, чадавхжуулах, салбар хоорондын хамтарсан дасгал сургуулилтыг жилдээ 4-өөс доошгүй удаа зохион байгуулна.
- Хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөх албан тушаалтны нэрсийг гаргана.
- Эрсдэлийн мэдээлэл харилцааны баг нь салбар хоорондын шуурхай мэдээллийн долоо хоног тутмын хэвлэлээр дамжуулан харилцан мэдээлэл солилцоно.

Эрсдэлийн түвшин “дунд”

- Олон нийтэд хүргэх мэдээллийг эрсдэлийн үнэлгээнд суурилан боловсруулж, холбогдох албан тушаалтнаар хянуулан баталгаажуулж, түгээхэд бэлтгэнэ. Энэ үед хянаж баталгаажуулсан албан мэдээллийг хамтрагч байгууллагууд өөрчлөхгүй байхад онцгой анхаарна.
- Зорилгод бүлгүүд, тэдний мэдээлэл, мэдлэгийн түвшинг тогтоож мэдээллийн стратеги төлөвлөгөөг гаргана.
- Шинэчлэгдсэн мэдээллийг хэрхэн яаж боловсруулж, түгээх талаар эрсдэлд орсон хүн амд хүргэх оновчтой хувилбарыг сонгоно.
- Томилогдсон албан тушаалтан, мэргэжилтнээр олон нийтэд хандаж мэдээлэл хийнэ.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, мониторинг хийж, цаашдын стратегийг боловсруулна .





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Эрсдэлийн үеийн мэдээлэл харилцаа

Эрсдэлийн түвшин **“өндөр”**

- ЭМХСХ баг нь эрсдэлийн түвшин нэмэгдэх үед дайчлах хүний нөөцтэй байх бөгөөд шинэчилсэн төлөвлөгөө боловсруулж, түншүүдтэй төлөвлөгөөний дагуу хамтран ажиллана.
- “Аюул, айдас аль аль нь их байна гэдгийг тайлбарлаж, хамтдаа даван туулахад боломж бүрийг ашиглах” зарчмыг баримтлана.
- Ерөнхий зохицуулагчын шийдвэрээр ЭМХСХ багийг нийгмийн эрүүл мэндийн үйл явдалд өртсөн бүс нутагт хүч нэмэгдүүлэн томилон ажиллуулна .
- Томилогдсон албан тушаалтан, мэргэжилтнээр олон нийтэд хандаж мэдээлэл өгүүлнэ.

Эрсдэлийн түвшин **“маш өндөр”**

- Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн үйл явдлын ноцтой байдлын мэдээллийг авмагц 2 цагийн дотор олон нийтэд мэдээлнэ.
- Хэвлэл мэдээллээр гарч буй бүхий л мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнг багийн гишүүдэд өдөр тутам мэдээлнэ. Иргэдийн дундах аман ярианд тогтмол мониторинг хийнэ.
- Мэдээлэл дамжуулах явцад холбогдох байгууллагуудын цахим хуудас, нүүр хуудсаар гаргаж байгаа мэдээллийн агуулга зөрүүгүй байна.
- Дотоод, гадаадын түнш байгууллагуудад үйл явдлын мэдээллийг тогтмол бэлтгэн хүргүүлнэ.
- Аюулд өртсөн иргэдийн тухай тогтмол мэдээлнэ.





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Эрсдэлийн үед олон нийтэд мэдээлэл өгөх албан тушаалтан

Эрсдэлийн түвшин **“маш өндөр”** үед мэдээллийг Ерөнхий сайд, эсвал Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга хүргэнэ.

Эрсдэлийн түвшин **“өндөр”** үед Засгийн газрын гишүүн, салбарын сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга нар хүргэнэ.

Эрсдэлийн түвшин **“дунд”** үед холбогдох салбарын удирдах албан тушаалтан буюу төрийн байгууллагуудын дарга, захирлууд хүргэнэ

Эрсдэлийн түвшин **“бага”** үед Эрсдэлийн мэдээлэл харилцааны багийн ахлагч, гишүүд, орон нутгийн удирдлага, төрийн байгууллага, агентлагийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд хүргэнэ.





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДАЛААЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Эрт мэдээлэх зарчим



ХӨСҮТ- 01.22-01.18
ЗӨСҮТ – 01.29-02.05



181,564 удаа үзсэн

Ikon News шууд нэвтрүүлж байсан.
19 цаг · 🌐

ЭМЯ-аас дэлхийн зарим оронд шинэ коронавирусийн халдвар гарсантай холбогдуулан мэдээлэл хийж байна





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДАЛАЛЫН УНДЭСНИЙ ТӨВ

Шинэ коронавирүсийн (nCoV) эхний хариу арга хэмжээний олон нийтийн оролцоо, эрсдэлийн үеийн харилцаа холбоо

Interim guidance v1

January 2020

[WHO/2019-nCoV/RCCE/v2020.1](#)



World Health Organization

Эрсдэлийн үеийн харилцаа холбоо, олон нийтийн оролцоо:

Эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийн талаар хүмүүс мэдээлэл авах эрхтэй учир эрсдэлд өртсөн хүн ам, олон нийттэй тогтмол харилцаж, тэдний төөрөгдөл үл ойлголцолыг арилгахад туслах

Тандалт, тохиолдлыг мэдээлэх, хавьтлыг илрүүлэх, эмнэлгийн тусламж, тухайн газарт дэмжлэг болох ложистикийн үйл ажиллагаанд хэрэгтэй хариу арга хэмжээ авахад чухал үүрэгтэй.

ЭҮХХОНО-ийг үр дүнтэй хэрэглэснээр дэгдэлтийг зогсоох, бүлэг хүн амыг хамгаалахад чиглэсэн хариу арга хэмжээг боловсруулдаг.

Нөлөөлөлд өртсөн хүн амын дунд:

Эрсдэлийн талаарх ойлголт мэргэжилтнүүдээс ялгаатай байдаг. Иймд иргэдэд шинжлэх ухааны мэдлэгийг ойлгомжтойгоор, хүртээмжтэй түгээх хэрэгтэй.





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Шинэ коронавирүсийн (nCoV) эхний хариу арга хэмжээний олон нийтийн оролцоо, эрсдэлийн үеийн харилцаа холбооны удирдамж

1. Зорилго
2. Эрсдэлийн үеийн харилцаа холбооны тогтолцоо
3. Дотоод болон оролцогч талуудын зохицуулалт
4. Олон нийтийн харилцаа холбоо
5. Нөлөөлөлд өртсөн иргэдийн харилцаа холбоо
6. Ойлгомжгүй, тодорхой бус болон буруу ойлголтыг шийдвэрлэх менежмент
7. Чадавхыг бэхжүүлэх





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

1. Зорилго

Болзошгүй дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах:

- Гэнэтийн, үл мэдэгдэх тохиолдлын үед харилцаа холбооны бэлэн байдал
- Үндэсний болон орон нутгийн түвшинд харилцаа холбооны чадавхийг үнэлэх (хүнийн болон нөөцийн)
- Мэдээлэх гол хүнийг тодорхойлох, хамтын ажиллагаа бий болгох
- ЭҮХХОНО-ний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, идэвхижүүлэх
- Ноцтой байдлын үед болон болзошгүй тохиолдлын үед ЭҮХХОНО-гийн ажилтнуудыг бэлтгэх, сургах

Нэг ба түүнээс дээш тохиолдол бүртгэгдсэн үед:

- Бэлэн байдлыг шалгах хуудснаас үйл ажиллагааны алхамаа хэрэгжүүлэх, нийцүүлэх
- Итгэлцлийг бий болгох эсвэл хадгалах замаар 2 талын харилцаа холбоог хөгжүүлэх – үл ойлголцол, ташаа мэдээлэл, цуурхал, нийтлэг асуултуудад хариулах
- Хамгаалах зан үйлийг хэрэгжүүлэхийг уриалах
- Хүлээгдэж буй эсвэл тодорхой бус тохиолдолд менежмент хийх
- Хариу арга хэмжээнд оролцож буй оролцогч талууд болон хамтын ажиллагааг уялдуулан, дэмжих
- Эрсдэлд өртсөн хүн ам болон нөлөөлөд өртсөн хүмүүсийн эхний ойлголтыг үнэлэх
- Гарын авлага, зааварчилгаа, мэдээллээр хангах





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

2. Эрсдэлийн үеийн харилцаа холбооны тогтолцоо

Болзошгүй дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангаж:

- Засгийн газрын хэмжээнд бэлэн байдал, хариу арга хэмжээ авахад ЭҮХХОНО хамруулахыг зөвшөөрч, мэдээллийг шуурхай, ил, тод, хүртээмжтэй байдлаар иргэдэд хүргэж байгаа эсэх
- Одоо хэрэгжүүлж буй төлөвлөгөө нь амьсгалын замын дэгдэлтийн үед хэрэглэж болох эсэх, түүнд нийцүүлэх
- Мэдээлэл, мессэж нь цаг хугацаандаа, шуурхай, үнэн зөв, бодит байгаа эсэх /журам/
- Харилцаа холбоонд хэрэгцээтэй санхүүгийн бэлэн байдал
- Эрсдэлийн үеийн харилцаа холбооны багийг бүрдүүлэх, үүрэг хариуцлагыг тодорхойлох

Нэг ба түүнээс дээш тохиолдол бүртгэгдсэн үед

- Хариу арга хэмжээнд одоо байгаа төлөвлөгөөг нийцүүлэх, багийг идэвхжүүлэх, төлөвлөгөө гаргах
- Ноцтой үед хэвлэлийн төлөөлөгчийг тодорхойлох, идэвхижүүлэх
- Харилцаа холбооны идэвхжлийн хуваарийг гаргах
- Нөлөөлөлд өртсөн хүн амд төөрөгдөл үүсгэдэг, мэдээллийн цаг хугацааг хойшлуулж буй үйл явцыг тодорхойлох замаар ЭҮХХОНО-ны хариу арга хэмжээг хянах





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

3. Дотоод болон оролцогч талуудын зохицуулалт

Болзошгүй дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах:

- Дэгдэлтийн үед ЭҮХХОНО-ны хариу арга хэмжээний багийг салбар хоорондын байгууллагаас бүрдүүлэх
- Оролцогч талуудын харилцаа холбоог үнэлэх, ашигладаг суваг, зорилтод үзэгчидыг тодорхойлох
- Стандарт үйл ажиллагааны гарын авлагын дагуу төлөвлөгөө болон үүрэг хариуцлагыг тодорхойлох (жишээ нь эхний мэдээллийг хэн хүргэх, ямар асуудлыг хөндөх, гол сэдэв/мессэж нь юу байх)

Нэг ба түүнээс дээш тохиолдол бүртгэгдсэн үед

- Оролцогч талууд болон бусад агентлаг, байгууллагуудын ЭҮХХОНО-г зохицуулахын тулд стандарт үйл ажиллагааг /SOP/ идэвхижүүлэх
- Үндэсний, орон нутгийн болон анхан шатны ЭҮХХОНО-ны үйл ажиллагааг холбох
- Дотоод (хариу арга хэмжээ бүрийг хариуцсан), гадаад (олон нийтэд) харилцаа холбоог томилох
- Зурвас бэлтгэх, түгээх, тогтвортой байдлыг зохицуулах



4. Нөлөөлөлд өртсөн иргэдийн харилцаа холбоо

Болзошгүй дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах:

- Гол үзэгчдийн санаа бодол, хандлага, итгэл үнэмшлийг ойлгох аргуудыг бий болгох
- Зорилтот үзэгчдийг тодорхойлох, мэдлэг, зан байдлын талаар мэдээлэл цуглуулах (итгэл үнэмшил, хэрхэн мэдээлэл авах боломжтой, зан байдал, төлөвшил гэх мэт)
- Олон нийтийн оролцоог хангах үүднээс одоо байгаа олон нийтийн нөлөөлөгч (нийгмийн ажилтан, шашны удирдагч, эрүүл мэндийн ажилчид, уламжлалтын эмч гэх мэт) болон сүлжээг (эмэгтэйчүүдийн бүлэг, эрүүл мэндийн сайн дурын ажилтан, эвлэл, хэсгийн ахлагч нар гэх мэт) тодорхойлох

Нэг ба түүнээс дээш тохиолдол бүртгэгдсэн үед

- Одоо байгаа албан болон албан бус мэдээлэлд үндэслэн эрсдэлийн талаарх ойлголтыг шуурхай дүгнэх
- Харилцаа холбооны хариу арга хэмжээг сонсогчдод зориулан түгээх (жишээ нь нөлөөлд өртсөн хүмүүс, эрүүл мэндийн ажилчид, улс төрийн албан тушаалтан, хандивлагч нар гэх мэт)
- Мэдээллийг тухайн хүмүүст тохируулан түгээх (орчуулах, бичиг үсэг тайлагдсан эсэх, боловсролын гэх мэт)





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

5. Ойлгомжгүй, тодорхой бус болон буруу ойлголтыг шийдвэрлэх менежмент

Болзошгүй дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах үед:

- Бүрэн дүр зураг мэдэгдэхээс өмнө удирдлагын зөвшөөрөл авч харилцаа холбоонд бэлтгэх
- Хяналтын тогтолцоо бий болгох, хэрэв шаардлагатай бол шар мэдээ, цуурхал, буруу ойлголт болон нийтлэг асуултад хариулах

Нэг ба түүнээс дээш тохиолдол бүртгэгдсэн үед

- Мэдэгдэж байгаа, мэдэгдэхгүй байгаа үед зохицуулах-тодорхойгүй байгаа зүйлийн талаар тайлбарлах
- Цуу яриаг хянах, хариу арга хэмжээний механизмыг идэвхжүүлэх
- ЭҮХХОНО-ны бүх ажилтнуудад шинэчлэгдсэн мэдээллийг тогмол өгөх талаар төлөвлөх
- Өвчтөн болон олон нийтээс ирүүлсэн мэдээлэл, санал хүсэлт, хэвлэл мэдээлэл, сошиал, утас болон эрүүл мэндийн ажилтнууд зэргийг хянаж-ЭҮХХОНО-ны төлөвлөгөө, стратегит нийцүүлэн тогтмол хэрэгжүүлж, эргэн мэдээлэх
- ЭҮХХОНО-ны ажилтнуудыг сургах, бэлтгэх
- Шаардлагатай бол ЭҮХХОНО-ны гарын авлага, удирдамжийн талаар хэвлэлийн ажилтан, төлөөлөгч, удирдлагуудыг сургахыг анхаарах





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

5. Чадавхийг бэхжүүлэх

ЭҮХХОНО хариу арга хэмжээний үеийн ажилтнуудад шинэ коронавирүсийн талаарх мэдээлэл, одоогийн төлөвлөгөө, журмын талаарх шаардлагатай сургалтыг анхаарах, орон нутгийн хэмжээн дэх ЭҮХХОНО ажилтнуудын бэлэн байдал хамаарна.





ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДАЛЛЫГ УНДЭСНИЙ ТӨВ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

